



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/227

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.7 дах заалт, Нийслэлийн Өргөө амаржих газар, Австрали Улсын Эпворт эрүүл мэндийн нэгдэл хооронд 2019 оны 5 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 3 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгох үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

081105

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 06 сарын 02-ны өдрийн
... дугаар тушаалтын хавсралт

**МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДАДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖЛИТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХУЧИНТЭЙ ХУГАЦАА**

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах гадаадын байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний серий/дугаар	Төрөлжсөн мэргэшшийн чиглэл	Зөвшөөрлийн линийн төрөл	Зөвшөөрлийн хучинтэй хугацаа
1.	Пофам Филип Андрю Брайн Popham Philip Andrew Bryan	Австрали Улс	Нийслэлийн Өргөө амаржих газар	Австрали Улсын Эпворт эрүүл мэндийн нэгдэл	ГЭ0002296	Мэдээлүүжүү лэг судлал	Эмчлэх /3 хоног/	2019.06.11-2019.06.13
2.	Винн Виллиамс Майкл Роберт Wynn Williams Michael Robert	Австрали Улс	Нийслэлийн Өргөө амаржих газар	Австрали Улсын Эпворт эрүүл мэндийн нэгдэл	ГЭ0002297	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх /3 хоног/	2019.06.11-2019.06.13
3.	Рийдман Эмма Readman Emma	Австрали Улс	Нийслэлийн Өргөө амаржих газар	Австрали Улсын Эпворт эрүүл мэндийн нэгдэл	ГЭ0002298	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх /3 хоног/	2019.06.11-2019.06.13